

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТАГТ ХЭРЭГЖИЖ БУЙ АВТО ЗАМЫН
САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХИЙГДСЭН
ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР
ДҮНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН


АУДИТЫН КОД: ӨВА-2024/29-1-ШТА-ГА



Арвайхээр хот
2024 он


Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор **О.Батжаргал**
Утас: 70323253, цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn
Аудитын менежер Д.Гансүх,
Утас: 70323833, цахим хаяг: Gansukhd@audit.gov.mn
Ахлах аудитор: П.Хорлоосүрэн,
Утас: 70323108, цахим хаяг: Khorloosuren@audit.gov.mn
Аудитор: Ө.Ринчинмядаг,
Утас: 70323108, цахим хаяг: Rinchinmyadagu@audit.gov.mn
Аудитор: Р.Энхзул,
Утас: 70323108, цахим хаяг: Enkhzulr@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой
нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn



АГУУЛГА

АГУУЛГА.....	1
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	3
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ.....	3
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ	4
БҮЛЭГ-1. АВТО ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХИЙГДСЭН ЗАРИМ ТАХ-г ТӨЛӨВЛӨХДӨӨ АЙМГИЙН ЖИЛИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ УЯЛДУУЛААГҮЙ, ХАА-н ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛААГҮЙ БАЙНА.	7
1.1. Авто замын сангийн хөрөнгөөр хийгдсэн зарим ТАХ нь аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй, хэрэгцээ шаардлагын дагуу ач холбогдлоор нь эрэмбэлж төлөвлөөгүй байна.	7
1.1.1. Авто замын сангийн хөрөнгөөр хийгдэх ТАХ-г төлөвлөхдөө Өвөрхангай аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулсан боловч аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд бүрэн тусгаагүй байна.....	7
1.1.2. Авто замын сангийн хөрөнгөөр хийгдэх ТАХ-г хэрэгцээ шаардлагын дагуу ач холбогдлоор нь эрэмбэлж төлөвлөөгүй байна.	8
1.1.3. Батлагдсан зураг төсвийн дагуу авто замын сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээг төлөвлөж, баталсан байна.	8
1.1.4. Авто замын сангийн орлогыг хууль, журмын дагуу төлөвлөж, төвлөрүүлсэн байна.	9
1.2. Аймгийн ХААГ-аас авто замын сангийн хөрөнгөөр хийгдсэн зарим ТАХ-ний тендерийн баримт материалыг ирүүлээгүй, Арвайхээр сумаас зарласан тендерийн баримт бичгийг үнэлгээний хороо хуралдаж боловсруулаагүй байна.	10
1.2.1. Тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу боловсруулсан боловч Арвайхээр сумаас зарласан тендерийн баримт бичгийг үнэлгээний хороо хуралдаж боловсруулаагүй байна.	10
1.2.2. Аймгийн ХААГ-аас Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан ч 2021 оны зарим тендерийн баримт материалыг ирүүлээгүй тул үзэх боломж гараагүй.	10
БҮЛЭГ-2. ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ЗАХИАЛАГЧ БАЙГУУЛЛАГЫН ЗҮГЭЭС ХЯНАЛТ ТАВИАГҮЙ, САНХҮҮЖИЛТИЙГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БОЛОВЧ ЗАРИМ ГҮЙЦЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГА ГЭРЭЭНИЙ ХУГАЦААНД АЖЛАА ДУУСГААГҮЙ БАЙХАД АЛДАНГИ ТООЦООГҮЙ БАЙНА.	12
2.1. Төсөл арга хэмжээг гүйцэтгэгч байгууллагууд гэрээний хугацааг мөрдөөгүй, бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгоогүй байна.	12
2.1.1.Төсөл арга хэмжээг гүйцэтгэгч байгууллагууд гэрээний хугацааг мөрдөөгүй байна.	12
2.1.2. Авто замын сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу зарцуулсан ч зарим хийгдээгүй ажилд санхүүжилт олгосон байна.	13
2.1.3. Авто замын сангийн хөрөнгөөр хийсэн зарим ТАХ-ний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй байна.	14
2.2. Захиалагч байгууллага гэрээний хэрэгжилтэд үе шатны хяналтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.....	14
2.2.1. Төсөл арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн тавих үе шатны хяналтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.	14
2.2.2. Мэргэжлийн байгууллагын зүгээс заавар, зөвлөгөө өгч, хяналт тавьж ажиллаагүй байна.	15



БҮЛЭГ-3. АВТО ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХИЙГДСЭН ИХЭНХ АЖЛУУД ИРГЭДЭД ҮР ДҮНГЭЭ ӨГСӨН БОЛОВЧ ЗАРИМ АЖЛУУД ЧАНАР БАЙДЛЫН ХУВЬД ХАНГАЛТГҮЙ ХИЙГДСЭН БАЙНА.....	15
3.1. Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ихэнх ажлууд иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байна.	15
3.2. Замын сангийн хөрөнгөөр хийгдсэн зарим ажил нь чанар байдлын хувьд хангалтгүй байна.....	17
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ	19
ДҮГНЭЛТ	20
ЗӨВЛӨМЖ.....	20
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ.....	22



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
УИХ	Улсын их хурал
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1	Авто замын сангийн хөрөнгөөр хийгдсэн ТАХ-ний төлөвлөлт	7
Хүснэгт 2	2021-2023 онд Авто замын сангаас хийхээр төлөвлөж, баталсан ажлын жагсаалт	8
Хүснэгт 3	Авто замын сангийн хөрөнгийн төлөвлөлт, гүйцэтгэл	9
Хүснэгт 4	Гэрээний үүргээ хугацаанд нь биелүүлээгүй гүйцэтгэгчид	12
Хүснэгт 5	Авто замын сангийн хөрөнгийн зарцуулалт	13
Дүрслэл 1	Авто замын сангийн хөрөнгөөр хийгдсэн ТАХ-ний ХАА	10



АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит нэр:

Аудитын код:

Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:

Аудитын зорилт:

Аудитын хамарсан хүрээ:

Орон нутагт хэрэгжиж буй авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн
ӨВА-2024/29-1-ШТА-ГА

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2023 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/162 дугаар тушаалаар батлагдсан сэдвийн дагуу, “Эрх шилжүүлэх тухай” Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны А/102 дугаар тушаалыг үндэслэн Өвөрхангай аймаг дах Төрийн аудитын газар хийж гүйцэтгэсэн.


Орон нутагт хэрэгжиж буй Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээний үр дүнд аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг Үндэсний аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Авто замын сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээг үндэслэлтэй төлөвлөж, орлогыг бүрэн төвлөрүүлж, ХАА хууль, журмын дагуу зохион байгуулагдсан эсэх
- Авто замын сангийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж хүлээн авсан эсэх.
- Авто замын сангийн хөрөнгөөр хийгдсэн төсөл арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх;

Аудитаар орон нутагт хэрэгжиж буй Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар 2021-2023 онуудад хийгдсэн төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн Төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харьяа байгууллагууд болон сумд, холбогдох бусад байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл, арга хэмжээний төлөвлөлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг хамруулан аудитыг хийж гүйцэтгэлээ.

Аудитаар Арвайхээр, Бат-Өлзий, Тарагт, Уянга, Хужирт, Хархорин, Зүүнбаян-Улаан, Хайрхандулаан, Өлзийт зэрэг сумдад талбар дээр ажилласан.



Аудитад хэрэглэсэн арга зүй:

Аудитыг АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-3100, АДБОУС-4000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нотлон шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах зэргээр Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, аудитын төлөвлөгөөнд тусгагдсан арга зүйг ашиглан гүйцэтгэлээ.

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль,
- Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Авто замын тухай хууль
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
- Дээрх хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, аймгийн ИТХ, Засаг даргын Захирамж, бусад эрхийн актууд
- Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоолоор баталсан “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”
- Засгийн газрын 2021 оны 160 дугаар, 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”
- Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам
- Батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, ажил гүйцэтгэх гэрээ

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

**Аудит хийх
багийн
бүрэлдэхүүн**

Аудитыг Дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Д.Гансүх хэрэгжүүлж, гүйцэтгэл-нийцлийн аудитын багийн ахлах аудитор П.Хорлоосүрэн, аудитор Ө.Ринчинмядаг, Р.Энхзул нар 2024 оны 9 дүгээр сарын 04-ний өдрөөс 11 дүгээр сарын 01-ний өдрүүдэд хийж гүйцэтгэлээ.

Үндсэн мэдээлэл:

Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар:

- Авто замын сангийн 2021 оны хөрөнгийг 851.0 сая төгрөгөөр төлөвлөж, аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 03/07 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн А/214 дүгээр захирамжаар 2021 онд 678.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан
- Авто замын сангийн 2022 оны хөрөнгийг 904.7 сая төгрөгөөр төлөвлөж аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 07/08 дугаар тогтоол, 2022 оны 5 дугаар сарын 18-ны 11/01 дүгээр тогтоолоор; аймгийн Засаг даргын 2022 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн А/162, 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/461 дүгээр захирамжаар 2022 онд 698.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталсан
- Авто замын сангийн 2023 оны хөрөнгийг 1,005.4 сая төгрөгөөр төлөвлөж аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 15/06 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн А/402 дугаар захирамжаар 2023 онд 562.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр тус тус байна.

Хүндрэл бэрхшээл:

Аймгийн Засаг даргын дэргэдэх Худалдан авах ажиллагааны алба авто замын сангийн хөрөнгөөр 2021-2023 онуудад гүйцэтгэсэн ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахтай холбоотой баримт материалыг удаа дараа шаардуулсан.

Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын тухайн үед ажиллаж байсан албан хаагч нар бүгд ажлаас гарсан байна.

Аудитаар нийт 705.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс 45.7 сая төгрөгийн 1 акт; 43.5 сая төгрөгийн 2 албан шаардлага; 4.3 сая төгрөгийн 6 зөвлөмж өгч; 93.5 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж тооцов.

АВТО ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХИЙГДСЭН ИХЭНХ АЖЛУУД ИРГЭДИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ ХАНГАСАН БОЛОВЧ ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТ ТАВИАГУЙГЭЭС ЗАРИМ АЖИЛ ЧАНАРГУЙ ХИЙГДСЭН БАЙНА.

БҮЛЭГ-1. АВТО ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХИЙГДСЭН ЗАРИМ ТАХ-Г ТӨЛӨВЛӨХДӨӨ АЙМГИЙН ЖИЛИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ УЯЛДУУЛААГУЙ, ХАА-н ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛААГУЙ БАЙНА.

1.1. Авто замын сангийн хөрөнгөөр хийгдсэн зарим ТАХ нь аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй, хэрэгцээ шаардлагын дагуу ач холбогдлоор нь эрэмбэлж төлөвлөөгүй байна.

1.1.1. Авто замын сангийн хөрөнгөөр хийгдэх ТАХ-г төлөвлөхдөө Өвөрхангай аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулсан боловч аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд бүрэн тусгаагүй байна.

Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 3 дугаар зүйлд заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагч буюу аймгийн Засаг дарга нь төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хөгжлийн бодлого, чиглэлд уялдуулан төлөвлөхөөр заасан байна.

Хүснэгт 1- Авто замын сангийн хөрөнгөөр хийгдсэн ТАХ-ний төлөвлөлт /сая.төг/

№	Хамаарах он	Төлөвлөн/Баталсан	
		Төсөл, арга хэмжээний тоо	Нийт дүн
1	2021	6	679.0
2	2022	8	700.0
3	2023	9	718.7
Нийт дүн		23	2,097.7


/эх сурвалж- ХБТХОХ-ийн ажлын баримтаас /

Авто замын сангийн хөрөнгөөр 2021-2023 санхүүжүүлэхээр төлөвлөсөн ажлууд нь Өвөрхангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 2 дугаар зүйлийн 2.1.1.4¹, 2.5.1.6², 2.5.1.7³; аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл

¹ 2.1.1.4. Улс, бүсийн чанартай, босоо болон хэвтээ тэнхлэгийн тээвэр, аялал жуулчлалын авто замын төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэлийг төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулж хэрэгжүүлнэ.

² 2.5.1.6. Сумын төвд хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн шугам сүлжээг бий болгон аж ахуй нэгж, гэр хорооллын айл өрхүүдийг холбон, орон сууцжуулах нөхцөлийг бүрдүүлж, авто болон явган хүний зам, гэрэлтүүлэг, ногоон байгууламж, үерээс хамгаалах далан сувгийг, төлөвлөлтийн дагуу хийнэ.

³ 2.5.1.7. Шинээр барих болон засварлах шаардлагатай орон нутгийн чанартай авто зам гүүрнүүдэд ажлын зураг, төсвийг хийлгэж барих, засварлах ажлыг гүйцэтгэнэ.



ажиллагааны хөтөлбөрийн 2 дугаар зүйлийн 2.1.1.2⁴, 2.5.2.1⁵, 2.5.2.8⁶ дахь заалтуудад нийцүүлэн төлөвлөсөн боловч аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд бүрэн тусгагдаагүй байна.

1.1.2. Авто замын сангийн хөрөнгөөр хийгдэх ТАХ-г хэрэгцээ шаардлагын дагуу ач холбогдлоор нь эрэмбэлж төлөвлөөгүй байна.

Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар 2021-2023 онд хэрэгжүүлэх ТАХ-төлөвлөхдөө аймаг, сумдын саналын нэгтгээгүй, Сангийн сайдын 2016 оны 415 тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 3 дугаар зүйлийн 3.6-д “Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн санхүүгийн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ нь тухайн захиалагчийн дунд хугацаанд хэрэгжүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй харилцан уялдсан байхын зэрэгцээ салбарын гол тэргүүлэх чиглэл, хөрөнгө оруулалтын ач холбогдол тухайн төслийн хэрэгжилттэй уялдуулан эрэмбэлсэн байна” гэж заасны дагуу хэрэгцээ, шаардлагаар нь эрэмбэлээгүй байна.

1.1.3. Батлагдсан зураг төсвийн дагуу авто замын сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээг төлөвлөж, баталсан байна.

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэж заасан ба 2021-2023 онд батлагдсан зураг төсөв, ажлын тоо хэмжээнд үндэслэн ТАХ-г төлөвлөсөн байна.

Авто замын сангийн хөрөнгөөр 2021-2023 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнүүдийг аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 03/07, 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 07/08, 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 15/06 дугаар тогтоолуудаар тус тус баталсан байна. Үүнд:

Хүснэгт 2- 2021-2023 онд Авто замын сангаас хийхээр төлөвлөж, баталсан ажлын жагсаалт /сая.төг/

№	Төсөл, арга хэмжээний нэр	2021 он	2022 он	2023 он
1	Авто замын асфальтбетон хучилтын ажил /Бат-Өлзий/	404.0		
2	Улсын чанартай А301 авто замаас Есөнзүйл, Хайрхандулаан сумдын төвийг холбох авто замын зураг төсөл	40.0		
3	Авто замын зураг төсөл /Арвайхээр сум, Од хороолол/	15.0		
4	Авто замын нөхөөс /Арвайхээр сум/	50.0		
5	Авто замын хагаралд, ан цав нөхөх /Арвайхээр сум/	20.0		
6	Нисэхийн зүүн талын замын шинэчлэлт, тохижилт /Арвайхээр сум/	150.0		
7	2021 оны авто замын сангийн үлдэгдэл санхүүжилт		78.6	
8	Сумдын авто замын нөхөөс, хагаралд ан цав хийх		100.0	
9	Авто замын хэвтээ тэмдэг тэмдэглэгээ		46.7	

⁴ 2.1.1.2. А0301, А0302 улсын чанартай авто замын дагуух Бүрд, Есөнзүйл, Өлзийт, Зүүнбаян-Улаан, Тарагт, Хайрхандулаан сумдыг хатуу хучилттай авто замаар холбох, “Арвайхээр-Хужирт-Бат-Өлзий”, “Хужирт-Төөхөн хийд-Улаан цутгалан”, “Арвайхээр-Баянгол-Сайхан Овоо-Цогт овоо”, “Арвайхээр-Гурван тэсШивээхүрэн”, “Чойр-Мандалговь-Арвайхээр”, А0302 улсын чанартай авто замаас Баянтээг баг хүртэлх 22 километр авто замуудыг шинээр барих зураг төсвийг хийлгэж, барьж эхлүүлнэ.

⁵ 2.5.2.1. Сумдын төвийн доторх хатуу хучилттай авто замын сүлжээг үе шаттайгаар нэмэгдүүлэн, Улаанбаатар Арвайхээрийн чиглэлийн 60 км авто замын шинэчлэлийг хийнэ.

⁶ 2.5.2.8. Сумдын төвд хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн шугам сүлжээг бий болгон аж ахуйн нэгж, гэр хорооллын айл өрхүүдийг холбон, орон сууцжуулах нөхцөлийг бүрдүүлж, авто болон явган хүний зам, гэрэлтүүлэг, ногоон байгууламж, үерээс хамгаалах далан сувгийг төлөвлөлтийн дагуу хийнэ.

10	Хархорин сумын авто замын нөхөөсний ажил		13.2	
11	Нийтийн эзэмшлийн зам, талбайн тохижилт		128.3	
12	Уянга сумын Бөөрөлжүүтийн голын модон гүүр барих		100.0	
13	Баянгол сумын Онгийн голын гүүрний шороон даланг засварлах		21.0	
14	Зүүнбаян-Улаан сумын Онгийн голын гүүрний шороон даланг засварлах		12.0	
15	Хаус хороолол доторх хайрган авто зам		200.0	
16	Тэмүүлэл Эрдэм сургуулийн авто зогсоол		84.0	
17	Хархорин сумын авто замын нөхөөс		20.0	
18	Хархорин сумын авто замын хэвтээ тэмдэг, тэмдэглэгээ		15.0	
19	Арвайхээр сумын авто замын нөхөөс, авто замд гагнаас хийх (зун)		52.5	
20	Арвайхээр сумын авто замын нөхөөс, авто замд гагнаас хийх (намар)		50.0	
21	Хайрхандулаан сумын гурван голын гүүрний засвар		8.5	
22	Арвайхээр сумын 4-р цэцэрлэгийн авто зогсоол		45.7	
23	Арвайхээр сумын авто замын тэмдэг, тэмдэглэгээ		20.0	
24	Арвайхээр хотын 1, 9 дүгээр багийн авто замыг улсын чанартай А0302 дугаар замтай холбох		423.0	
НИЙТ ДҮН		679.0	700.0	718.7

/эх сурвалж- Аймгийн ИТХ тогтоолууд /

Арвайхээр, Зүүнбаян-Улаан, Баянгол, Бат-Өлзий сумдад хийхээр баталсан ТАХ-ний саналыг албан бичгээр ХБТХОХ-т сумдаас хүсэлтээ ирүүлээгүй байхад аймгаас шууд санал оруулж төлөвлөн баталсан байна.

1.1.4. Авто замын сангийн орлогыг хууль, журмын дагуу төлөвлөж, төвлөрүүлсэн байна.

Авто замын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2⁷, Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “АВТО ЗАМЫН САНД ХӨРӨНГӨ ТӨВЛӨРҮҮЛЭХ, ЗАХИРАН ЗАРЦУУЛАХ ЖУРАМ”-н 2 дугаар зүйлд заасан 7 төрлийн хөрөнгийг авто замын санд төвлөрүүлнэ гэж заасан. Өвөрхангай аймгийн хувьд 2 төрлийн орлогыг 2021-2023 онд төлөвлөж, бүрдүүлсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3- Авто замын сангийн хөрөнгийн төлөвлөгөө, гүйцэтгэл /сая.төг/

№	Эх үүсвэрүүд	2021 он		2022 он		2023 он	
		Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц
1	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	600.0	725.0	652.8	781.6	718.7	920.3
2	Орон нутгийн авто зам, зогсоол ашигласны төлбөр	251.0	281.5	251.9	293.4	286.7	340.5
НИЙТ ДҮН		851.0	1,006.5	904.7	1,075.0	1,005.4	1,260.8

/эх сурвалж- СТСХ-ийн ажлын баримтаас /

Дээрх хоёр төрлийн орлогыг дараах байдлаар төлөвлөсөн байна. Үүнд:

Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг төлөвлөхдөө:	Орон нутгийн авто зам, зогсоол ашигласны төлбөрийг төлөвлөхдөө:
--	---

⁷ 25.2.1.авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар;

25.2.2.нийслэл, орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө;


25.2.3.гадаадын зээл, тусламж, хандивын хөрөнгө;

25.2.4.нийслэл, орон нутгийн авто зам дээр хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгууль;

25.2.5.нийслэл, орон нутгийн авто зам, зогсоол ашигласны төлбөр;

25.2.6.авто замын зурвас газарт холбогдох зөвшөөрлийн дагуу үйлчилгээ эрхэлсний төлбөр;

25.2.7.бусад.



- Аймгийн хэмжээнд бүртгэлтэй нийт тээврийн хэрэгсэлд ногдох татварын хэмжээгээр;
- Бүртгэлтэй тээврийн хэрэгслийн 90 хувь нь орон нутгийн зам ашиглахаар төлөвлөн баталсан байна.

Дээрх 2 төрлийн орлогоос хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлж, ХБТХОХ-ээс ирүүлсэн саналд үндэслэн Аймгийн ИТХ-ын тогтоолоор аймгийн авто замын сангийн хөрөнгөөр хийгдэх ТАХ-ний санхүүжилтийг 2021 онд 679.0 сая төгрөг, 2022 онд 700.0 сая төгрөг, 2023 онд 718.7 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

1.2. Аймгийн ХААГ-аас авто замын сангийн хөрөнгөөр хийгдсэн зарим ТАХ-ний тендерийн баримт материалыг ирүүлээгүй, Арвайхээр сумаас зарласан тендерийн баримт бичгийг үнэлгээний хороо хуралдаж боловсруулаагүй байна.

1.2.1. Тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу боловсруулсан боловч Арвайхээр сумаас зарласан тендерийн баримт бичгийг үнэлгээний хороо хуралдаж боловсруулаагүй байна.

Авто замын сангийн хөрөнгөөр хийгдсэн 23 төсөл арга хэмжээний 16 ТАХ-г хуулийн дагуу тендер зарлаж “Тендерийн жишиг баримт бичиг”-ийн дагуу боловсруулж тендерийн урилгыг www.tender.gov.mn цахим сайтад мэдээлж, 5-н суманд 2022-2023 оны 7 ажлын тендерийн эрхийг шилжүүлжээ.

Харин Арвайхээр сумын 4-р цэцэрлэгийн авто зогсоолын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичгийг Үнэлгээний хороо хуралдаж боловсруулаагүй байна. Энэ нь тухайн үед мөрдөгдөж байсан ТБОНӨХБАУХА тухай хуулийн 47.2.1.”техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, тендерийн баримт бичгийг боловсруулах, тендер хүлээн авах, тендер нээх ажиллагааг холбогдох зааврын дагуу гүйцэтгэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2.2. Аймгийн ХААГ-аас Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан ч 2021 оны зарим тендерийн баримт материалыг ирүүлээгүй тул үзэх боломж гараагүй.

Аймгийн авто замын сангийн хөрөнгөөр 2021-2023 онд хэрэгжүүлсэн нийт 23 ТАХ-ээс 2 нь зураг төсвийн ажил, 21 авто замын ажил бөгөөд үүнээс аймгийн Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/461 тоот захирамжаар 3 ажлыг, 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/402 тоот захирамжаар 4 ажлыг тус тус Арвайхээр, Хархорин, Зүүнбаян-Улаан, Уянга, Баянгол сумдад эрх шилжүүлсэн байна.

Худалдан авах ажиллагааг НТШ-ын аргаар 7 ТАХ-г, хязгаарлагдмал тендер шалгаруулалтын аргаар 5 ТАХ-г, харьцуулалтын аргаар 4 ТАХ-г зохион байгуулсан, 4 ТАХ-ний гүйцэтгэгчтэй шууд худалдан авалт, хэрэгжээгүй 1, хэмнэлт үүсэн төвлөрүүлсэн 2 ТАХ байна. Тодруулбал:

Дүрслэл 1-Авто замын сангийн хөрөнгөөр хийгдсэн ТАХ-ний ХАА

НЭЭЛТТЭЙ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН АРГААР	ХЯЗГААРЛАГДМАЛ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН АРГААР	ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР	ШУУД ГЭРЭЭ БАЙГУУЛСАН
- Нисэхийн зүүн талын 1км авто замын шинэчлэл - 806.0 сая төгрөг - Нийтийн эзэмшлийн зам, талбайн тохижилт - 128.3 сая төгрөг - Уянга сумын Бөөрөлжүүтийн голын модон гүүр барих - 448.2 сая төгрөг - Хаус хороолол доторх хайрган авто зам - 200.0 сая төгрөг - Тэмүүлэл эрдэм сургуулийн авто зогсоол - 84.0 сая төгрөг - Арвайхээр сумын авто замын нөхөөс, авто замд гагнаас хийх/Зун/- 52.5 сая төгрөг - Арвайхээр хотын 1, 9-р багийн авто замыг улсын чанартай А0302 дугаар авто замтай холбох - 1100.0 сая төгрөг	- Бат-Өлзий сумын авто замын асфальтбетон хучилтын ажил - 487.0 сая төгрөг - Есөнзүйл сум, Хайрхандулаан сумдын төвийг улсын чанартай авто замтай холбох авто замын зураг төсөв - 40.0 сая төгрөг - Арвайхээр сумын Од хорооллын доторх авто замын зураг төслийн ажил - 15.0 сая төгрөг - Арвайхээр сумын авто замын нөхөөс - 50.0 сая төгрөг - Авто замын хагарал, ан цав нөхөх - 20.0 сая төгрөг	- Сумдын автозамын нөхөөс, хагаралдан цав хийх - 46.7 сая төгрөг - Сумдын автозамын нөхөөс, хагаралдан цав хийх - 100.0 сая төгрөг - Баянгол сумын Онгийн голын гүүрний шороон даланг засварлах - 21.0 сая төгрөг - Арвайхээр сумын 4-р цэцэрлэгийн авто зогсоол - 45.7 сая төгрөг	- Хархорин сумын автозамын нөхөөс, хагаралдан цав хийх - 13.2 сая төгрөг - Зүүнбаян-Улаан сумын Онгийн голын гүүрний шороон даланг засварлах ажил - 12.0 сая төгрөг - Хархорин сумын авто замын нөхөөс - 20.0 сая төгрөг - Хархорин сумын авто замын хэвтээ тэмдэг, тэмдэглэгээ - 15.0 сая төгрөг

/эх сурвалж-www.tender.gov.mn/

Хэрэгжээгүй ТАХ:

- Хайрхандулаан сумын гурван голын гүүрний засвар – 8.5 сая төгрөг

Хэмнэлт үүсэж төвлөрүүлсэн:

- Арвайхээр сумын авто замын нөхөөс, авто замд гагнаас хийх /Намар/ - 50,0 сая төгрөг
- Арвайхээр сумын авто замын тэмдэг, тэмдэглэгээ- 20.0 сая төгрөг

Аймгийн худалдан авах ажиллагааны газраас авто замын сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлсэн Хязгаарлагдмал тендер шалгаруулалтын аргаар зарласан 5 багц тендерийн баримт материалыг ирүүлэхийг удаа дараа шаардсан боловч тендерийн баримт материалыг аудитын явцад ирүүлээгүй. Үүнд:

- Бат-Өлзий сумын авто замын асфальт бетон хучилтын ажил -487.0 сая төгрөг
- Арвайхээр сумын авто замын нөхөөс -50.0 сая төгрөг
- Арвайхээр сумын авто замын хагарал ан цав нөхөх -20.0 сая төгрөг
- Есөнзүйл сум, Хайрхандулаан сумдын төвийг улсын чанартай авто замтай холбох авто замын зураг төсөв -40.0 сая төгрөг
- Арвайхээр сумын Од хорооллын доторх авто замын зураг төслийн ажил 15.0 сая төгрөг

Хархорин сумын авто замын нөхөөс – 20.0 сая төгрөг, авто замын хэвтээ тэмдэг, тэмдэглэгээ – 15.0 сая төгрөгийн 2023 оны ажлыг хуулийн дагуу худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй шууд гэрээ байгуулсан нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 8.1.1 дэх заалтуудыг зөрчсөн байна.⁸

Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааны зарим ажлуудаас дурдвал:

⁸ 8.1.1. "харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар", 33.1. "бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно", Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн "Босго үнэ шинэчлэн тогтоох тухай" 124 дугаар тогтоолын "Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар"

- Нисэхийн зүүн талын 1км авто замын шинэчлэлийн ажлыг 2021 онд ОНХС-аас 656.0 сая төгрөг, авто замын сангаас 150.0 сая төгрөг нийт 806.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн. Тус тендерт “Өндөрсант хайрхан” ХХК – 801.1 сая төгрөгөөр, “Огторгуйн бүтээл” ХХК – 744.2 сая төгрөгөөр тус тус үнийн санал ирүүлсэн байна. “Өндөрсант хайрхан” ХХК үзүүлэлтийг хангаагүй тул тус тендерээс татгалзах үндэслэл болж “Огторгуйн бүтээл” ХХК шалгарсан байна.
- Уянга сумын Бөөрөлжүүтийн голын модон гүүр барих ажлыг 2022 онд нийт 448.2 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөснөөс 100.0 сая төгрөгийг авто замын сангаас гаргасан байна. Тус тендерт Хурд час ХХК 440.5 сая төгрөгөөр үнийн санал ирүүлсэн боловч тендерийн тавигдах шаардлага хангаагүй тул дахин тендерийг хүчингүй болгон дахин зарлан “Шоо констракшн” ХХК – 445.0 сая төгрөгөөр, “Хурд час” ХХК – 440.5 сая төгрөгөөр тус тус үнийн санал ирүүлсэн бөгөөд тендерийн тавигдах шаардлага хангаагүй тул дахин тендер хүчингүй болж ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 30 дугаар зүйлийн дагуу “Хурд час” ХХК-тай шууд гэрээ байгуулсан байна.
- Арвайхээр хотын 1, 9-р багийн авто замыг улсын чанартай А0302 дугаар авто замтай холбох ажлыг 2023 онд зарлан Өвөрхангай АЗЗА – 1039.4 сая төгрөгөөр, “Өндөр сант хайрхан” ХХК – 1009.5 сая төгрөгөөр тус тус үнийн санал ирүүлжээ. Тус тендерийг хянан үзэхэд Өвөрхангай АЗЗА-н холбогдох зарим баримт нь тендерийн баримт бичгийн шаардлагыг хангаагүй тул тендерээс татгалзах үндэслэл болж, “Өндөр сант хайрхан” ХХК-ны ирүүлсэн тендер нь шаардлагад нийцсэн тул гэрээ байгуулсан байна.

БҮЛЭГ-2. ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ЗАХИАЛАГЧ БАЙГУУЛЛАГЫН ЗҮГЭЭС ХЯНАЛТ ТАВИАГҮЙ, САНХҮҮЖИЛТИЙГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БОЛОВЧ ЗАРИМ ГҮЙЦЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГА ГЭРЭЭНИЙ ХУГАЦААНД АЖЛАА ДУУСГААГҮЙ БАЙХАД АЛДАНГИ ТООЦООГҮЙ БАЙНА.

2.1. Төсөл арга хэмжээг гүйцэтгэгч байгууллагууд гэрээний хугацааг мөрдөөгүй, бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгоогүй байна.

2.1.1.Төсөл арга хэмжээг гүйцэтгэгч байгууллагууд гэрээний хугацааг мөрдөөгүй байна.

Авто замын сангийн хөрөнгөөр 2021-2023 онд санхүүжүүлсэн доорх төсөл арга хэмжээг гэрээний хугацаанд ажлаа бүрэн гүйцэтгэж, хүлээлгэж өгсөн байна. Үүнд:

“ӨВ АЗЗА” ТӨХК-ийн гүйцэтгэсэн

- Бат-өлзий сумын төвд авто замын асфальт бетон хучилтын 1202 урт метртэй ажлыг 482.7 сая төгрөгөөр
- Арвайхээр сумын Нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт хийх ажлыг 128.3 сая төгрөгөөр
- Арвайхээр сумын авто замын нөхөөс, авто замд гагнаас хийх ажлыг 52.5 сая төгрөгөөр хийгдсэн ажлууд гэрээний хугацаанд хийгдэж хүлээлгэн өгсөн байна.

Ихэнх гүйцэтгэгч байгууллагууд гэрээний хугацаанд ажлаа бүрэн гүйцэтгээгүй, олон хоног хэтрүүлж хүлээлгэж өгсөн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4- Гэрээний үүргээ хугацаанд нь биелүүлээгүй гүйцэтгэгчид /мян.төг/

№	TAX хэрэгжүүлэгчийн нэр	Хөрөнгө оруулалтын нэр	Мөнгөн дүн	Хугацаа хэтэрсэн хоног	Алдангийн дүн
1	“Огторгуйн бүтээл” ХХК	Арвайхээр сумын Нисэхийн зүүн талын 1 км урттай авто замын шинэчлэл	150,000.0	56	840.0
2	“Хас гарьд констракшн” ХХК	Арвайхээр сумын Тэмүүлэл эрдэм сургуулийн авто зогсоол	83,000.0	12	99.6
3	“Хурд час” ХХК	Уянга сумын Бөөрөлжүүтийн гол дээр модон гүүр барих	100,000.0	118	1180.0
4	“Арвайхээр нийтийн тээвэр, гэрэлтүүлэг” ОНӨААТҮГ	Авто замын хэвтээ тэмдэг, тэмдэглэгээг хийх ажил гүйцэтгэх	46,700.0	27	126.1
5	“Өндөрсант Хайрхан ” ХХК	Арвайхээр хотын 1,9-р багийн авто замыг улсын чанартай авто замтай холбох	317,900.0	4	127.2
6	“ӨВ АЗЗА” ТӨХК	Сумдын авто замын нөхөөс, хагаралд ан цав хийх	68,700.0	85	584.0
7		Хаус хороолол доторх хайрган автозам	199,900.0	55	1099.5
8		Арвайхээр сумын автозамын нөхөөс, хагаралд ан цав хийх	98,900.0	24	237.4
	ДҮН		1,065,100.0	381	4293.61

/эх сурвалж- ХБТХОХ-ийн ажлын баримтаас /

Дээрх хүснэгтээс харахад нийт 8 төрлийн 1065.1 сая төгрөгийн ТАХ хугацаа хэтэрч 4.3 сая төгрөгийн алданги тооцож хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудыг ашиглалтад хүлээн авах акт, дүгнэлтийг үндэслэн үлдэгдэл санхүүжилтээс гэрээнд заасны дагуу алдангийг суутган тооцоогүй байна.

Гэрээний хариуцлагын хэсэгт тусгагдсан барилга угсралт, засварын ажлыг гэрээт хугацаандаа ашиглалтад өгөөгүй бол хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.01 хувьтай тэнцэх торгуулийг хоцорсон хоног тутамд төлөхөөр гэж заасан боловч хэрэгжихгүй байна. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хугацаандаа дуусаагүй төсөл, арга хэмжээний хариуцлагын талаар тодорхой тусгаагүйгээс хугацаа хэтэрсэн ТАХ-нд алданги, хариуцлага тооцоогүй байна.

2.1.2. Авто замын сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу зарцуулсан ч зарим хийгдээгүй ажилд санхүүжилт олгосон байна.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 8 дугаар сарын 7-ны өдрийн 312 дугаар тогтоолын “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”-ыг үндэслэн зарцуулж ирсэн байна.

Авто замын сангийн хөрөнгийн зарцуулалтыг 3 жилээр харуулбал:

Хүснэгт 5- Авто замын сангийн хөрөнгийн зарцуулалт /сая.төг/

№	Зардлын төрөл	2021		2022		2023	
		ТАХ-ний тоо	Мөнгөн дүн	ТАХ-ний тоо	Мөнгөн дүн	ТАХ-ний тоо	Мөнгөн дүн
1	Гүйцэтгэгчид өгсөн санхүүжилт	6	642.2	8	685.6	5	546.1
2	Техник хяналтын зардалд		36.8		13.0		16.7
	Нийт санхүүжилт	6	679.0	8	698.6	5	562.8

/эх сурвалж- СТСХ-ийн ажлын баримтаас /

Авто замын сангийн техник хяналтын зардлыг тухай бүрд нь анхан шатны баримтыг үндэслэж олгоогүй, оны эцэст барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлсэн байна.⁹

Авто замын сангийн хөрөнгөөр хийгдээгүй Арвайхээр сумын 4 дүгээр Цэцэрлэгийн авто зогсоол хийх ажлыг уламжилсан албан тоот, ажлын зураг төсөв, тоо хэмжээ ирүүлээгүй байхад суманд нь эрх олгож 45.7 сая төгрөгийг 2023 оны 12 дугаар сарын 12-нд шилжүүлсэн байна. Тухайн ажлыг 2022 онд хувийн хэвшлийн 45.7 сая төгрөгөөр хийсэн авто зогсоолд санхүүжилтийг нөхөн олгох зориулалтаар, баримт материалгүй хөрөнгө төлөвлөж өгсөн байна.



2.1.3. Авто замын сангийн хөрөнгөөр хийсэн зарим ТАХ-ний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй байна.


Авто замын сангийн хөрөнгөөр 2021 онд 678.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл арга хэмжээ, 2022 онд 698.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл арга хэмжээ, 2023 онд 562.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан байна. Гэрээний дагуу ажлын гүйцэтгэлийг холбогдох албан тушаалтнуудаар батлуулж, зураг, актаар баталгаажуулан нэхэмжлэлийг үндэслэн санхүүжилтээ олгосон боловч дараах ажил хийгдээгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон байна. Тухайлбал: Хайрхандулаан сумын Засаг даргын 2023 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 1/32 тоот албан бичгээр 2020 оны үерт нэрвэгдсэн гүүрний даланг засварлах ажилд 8.5 сая төгрөгийг шийдвэрлүүлэхээр хүсэлт ирүүлсний дагуу Авто замын сангаас тус хөрөнгийг шийдвэрлэсэн байна. Гүүрний засварын ажилд 20.0 сая төгрөг шаардлагатай байсан боловч төсөвт өртөг нь хүрэхгүйгээс одоог хүртэл гүүрний засварын ажил хийгдээгүй байна.

2.2. Захиалагч байгууллага гэрээний хэрэгжилтэд үе шатны хяналтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.2.1. Төсөл арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн тавих үе шатны хяналтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өвөрхангай аймгийн ЗДТГ-т авто замын барилгын үе шат бүрийн ажилд захиалагчийн хяналтыг тавих мэргэжлийн боловсон хүчин байхгүйгээс авто замын норм, дүрэм, стандарт, чанар байдлыг хангуулан ажиллаагүй, зураг төсөв буруу

⁹ 3.2. Авто замын сангийн хөрөнгийг Авто замын тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга тус тус зориулалтын дагуу захиран зарцуулна.



хийгдсэнээс төсвийн хөрөнгийн зарцуулалт зарим ажлын хувьд үр дүн муутай болсон байна.

Тухайлбал: Арвайхээр сумын Хаус хороолол доторх хайрган авто зам 199.9 сая төгрөгөөр хийгдсэн боловч зургийн алдаанаас болж зарим айлуудын гэрт үерийн ус орсон байна. Тухайн орчинд оршин суугчид зам ашиглалтад орсноос хойш гомдол гарсаар байгаа боловч одоог хүртэл арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Авто замын барилгын үе шат бүрд хяналтыг мэргэжлийн байгууллагаар гэрээний үндсэн дээр хийлгээгүй байгаа нь Авто замын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг эрх бүхий мэргэжлийн байгууллага захиалагчтай гэрээ байгуулсны үндсэн дээр хэрэгжүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аймгийн МХГ татан буугдах гэж байгаа шалтгаанаар хяналтын улсын байцаагч нь 2021-2023 онд орон нутгийн чанартай хатуу хучилттай авто замуудын ашиглалт, засвар арчлалтын үйл явцад хяналт, шалгалт хийгээгүй байна.

Төсөл арга хэмжээгээр хийгдсэн ажлуудыг ажил хүлээлцэх комиссын гишүүдээс дутуу хийсэн ажлуудыг үүрэг даалгавар өгч, саналын хуудас бичсэн боловч тухайн зөрчлийг арилгасан эсэхийг тэмдэглэл үйлдэж баримтжуулаагүй байна.

2.2.2. Мэргэжлийн байгууллагын зүгээс заавар, зөвлөгөө өгч, хяналт тавьж ажиллаагүй байна.

Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ээс авто замын сангийн хөрөнгөөр 2021-2023 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд мэргэжлийн заавар, зөвлөгөө өгч ажилласан талаарх баримт, материалыг аудитын явцад ирүүлээгүй.

Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ын Хяналтын улсын байцаагч нь 2021-2022 онд Ковид-19 цар тахалтай холбоотой, 2023 онд аймгийн МХГ нь татан буугдаж, бүтцийн өөрчлөлт орохтой холбоотой хяналт тавиагүй гэсэн тайлбар өгсөн.

БҮЛЭГ-3. АВТО ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХИЙГДСЭН ИХЭНХ АЖЛУУД ИРГЭДЭД ҮР ДҮНГЭЭ ӨГСӨН БОЛОВЧ ЗАРИМ АЖЛУУД ЧАНАР БАЙДЛЫН ХУВЬД ХАНГАЛТГҮЙ ХИЙГДСЭН БАЙНА.

3.1. Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ихэнх ажлууд иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байна.

Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар 2021-2023 онд хийгдсэн ажлуудаас дараах ажлууд иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Арвайхээр сумын шинэ суурьшлын бүс рүү зорчих хэсэг болох Нисэхийн зүүн талын замын шинэчлэлт, тохижилтын ажлаар 2021 онд Огторгуйн бүтээл ХХК-ийн хийсэн 1 км авто замын ажил Тухайн зам ашиглалтад орсноор Арвайхээр сумын шинэ суурьшлын бүсэд амьдарч байгаа нийт 1558 өрхийн 5595 иргэд зорчиж үр өгөөжөө өгсөн байна. Мөн шинэ суурьшлын бүсэд төрийн байгууллагуудын байр төвлөрч байгаа тул иргэдийн зорчих хөдөлгөөн ихсэж үр дүнгээ өгч байна.

- “Хурд Час” ХХК-ийн 2022 онд шинээр хийсэн Уянга сумын Бөөрөлжүүтийн голын модон гүүр нь иргэдийн чөлөөтэй зорчих боломжийг бүрдүүлсэн. Гүүр ашиглалтад орсноор хол тойруу замыг туулан сумын төв рүү зорчдог байсан хөдөөгийн багийн нийт 734 өрхийн 2485 хүн ам нь гүүрээр дамжин цаг хугацаагаа хэмнэж иргэдийн тээврийн хэрэгслээр зорчих аюулгүй таатай нөхцөлийг бүрдүүлсэн төдийгүй иргэд, байгууллагуудын шатахууны зардал хэмнэгдэж байна.
- Арвайхээр хотын 1, 9 дүгээр багийн авто замыг улсын чанартай А0302 дугаар замтай холбох ажлыг Өндөр сант хайрхан ХХК-ийн 2023 онд хийж гүйцэтгэсэн бөгөөд тус хорооны иргэд улсын чанартай зам руу шууд зорчих боломж бүрдсэн. Тухайн зам ашиглалтад орсноор Арвайхээр сумын 1,9 дүгээр багт оршин сууж буй 1612 өрхийн нийт 5,731 иргэний амьдрах орчин сайжирч, төв зам руу шууд зорчих таатай нөхцөл бүрдэж, үр өгөөжөө өгсөн байна.



Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар 2021-2023 онд хийгдсэн ажлуудаас дараах ажлууд иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй байна. Үүнд:

- ӨВ АЗЗА ТӨХК-ийн 2022 онд хийж гүйцэтгэсэн Арвайхээр сумын Хаус хороолол доторх хайрган авто зам нь зураг төсвийн дагуу хийгдээгүй, төлөвлөлтийн алдаанаас үүдэн тус хорооллын айл өрхүүдэд их хэмжээний ус тогтох, бохир халих зэрэг асуудлууд үүсэж иргэдийн эрх зөрчигдөж, хүнд нөхцөл байдалтай байна.



- Зүүнбаян-Улаан сумын Онгийн голын гүүрний шороон даланг засварлах ажлыг тооцоо судалгаанд үндэслээгүй 12.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч дахин эвдрэл үүсэж иргэд зорчих боломжгүй болсон байна. Тус гүүрийн засварт сумын ОНХС-аас 2024 онд дахин 30.0 сая төгрөг төлөвлөсөн байна.



3.2. Замын сангийн хөрөнгөөр хийгдсэн зарим ажил нь чанар байдлын хувьд хангалтгүй байна.


Авто замын сангийн хөрөнгөөр хийгдсэн зарим ажлуудын чанар байдал, ашиглалт талаас нь дурдахад:

- Арвайхээр хотын 1, 9 дүгээр багийн авто замыг улсын чанартай А0302 дугаар замтай холбосон зам нь зураг төсөвт заагдсан хэмжээний дагуу чанартай хийгдсэн боловч “Авто замын хажуугаар хийгдсэн шуудууны ажлыг чулуугаар бэхлэх- 1755м.кв” ажил хийгдээгүй байна. Энэ нь үерийн шуудуунд ус цуглуулах явцад хөрсний элэгдэл үүсгэх эрсдэлийг бий болгох, цаашлаад замын хөвөө, далангийн ашиглалтад сөргөөр нөлөөлөхүйц байна.

Тус замын зураг төслийг “Тарваченбүүлэн” ХХК хийж гүйцэтгэсэн бөгөөд зураг төсөв алдаатай хийгдэж, ажлыг гүйцэтгэх явцад хүндрэл үүссэн байна. Тус авто замыг холбох ажлыг “Өндөрсант Хайрхан” ХХК хийж гүйцэтгэхээр 2023 оны 3 дугаар сарын 06-нд гэрээ хийгдсэн. Зураг төсвийн алдаатай байдлыг засварлаж, зургийг шинэчлэн замын ажил эхэлснээс хойш “Тарваченбүүлэн” ХХК 2023 оны 4 дүгээр сарын 27-нд хүлээлгэн өгсөн байна. Улсын чанартай авто замын зүүн талын хэсгээс шинээр хийгдсэн зам руу эргэх зорчих хэсгийн зай бага учраас том оврын автомашин эргэлт хийх боломжгүй байдалтай байна.



- Бат-Өлзий суманд “Сумын хөгжил, инженерийн дэд бүтцийн хангамж” төслийн хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 оноос эхлэн



хийгдэж буй цэвэр, дулаан, ариутгах татуургын ажлын явцад 2021 онд авто замын сангийн хөрөнгөөр хийгдсэн асфальтан замд эвдрэл үүссэн байна.



Бат-Өлзий сумын авто замын асфальт бетон хучилттай зам

- Хархорин сумын авто замын нөхөөс хийх ажлыг 36.4 сая төгрөг; авто замын хэвтээ тэмдэг, тэмдэглэгээ хийх ажлыг 23.3 сая төгрөгөөр тус тус төсөвлөн аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-т санал хүргүүлсэн боловч тус ажлууд тооцсон төсвөөс бага дүнгээр буюу 20.0 сая, 15.0 сая төгрөгөөр тус тус баталж хийгдсэн тул тухайн замын ажил бүрэн хийгдэж чадаагүй байна.
- Авто замын сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудыг хүлээн авах үед барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын өгсөн үүрэг даалгаврууд бүрэн биелэгдээгүй дараах ажлууд байна. Үүнд:
- Хаус хороолол доторх хайрган авто замын ажлыг 2022 онд хийх үед тус хорооллын голоор байрлах замтай холбосон уулзварын эхлэл хэсгийн явган хүний зам, асфальт бетон, гарц эвдэгдсэн ба 2023 оны 5 дугаар сард багтаан тус эвдрэлийг засварлах
- Авто тээврийн газрын гадна талбайн 2022 онд хийгдсэн ажлаас дутуу хийгдсэн зогсоолын талбайн урд хэсгийн 15 метр газарт хэвтээгээр авто замын хашлага байрлуулах
- эмүүлэл эрдэм сургуулийн авто зогсоолын баруун талын хэсэгт ус орох лотки хийх.



Хаус хороолол доторх хайрган авто зам

Авто тээврийн газрын гадна талбай

Тэмүүлэл эрдэм сургуулийн авто зогсоол



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,

Утас/Факс: (976) 7032 2073,

Цахим шуудан: uvurkhangai@ov.gov.mn

Цахим хуудас: www.uvurkhangai.mn

2024.11.14 № 3/510

танай _____-ны № _____-т

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Орон нутагт хэрэгжиж буй авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын тайланд өгөх саналгүй болно.



6224 33 0815

D:My Doc. A5 alban bichig /ZDTG/



ДҮГНЭЛТ

1. Авто замын сангийн хөрөнгөөр хийгдсэн зарим ТАХ нь аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй байна.
2. Аймгийн ХААГ-аас 2021 оны авто замын сангийн хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах 1 багц тендерийн баримт материалуудыг ирүүлээгүй тул гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулагдсан эсэхийг үзэх боломжгүй байлаа.
3. Төсөл арга хэмжээг гүйцэтгэгч зарим байгууллага нь ажил дуусах хугацааг хэтрүүлсэн, захиалагч нь хугацаа хэтэрсэнд алданги тооцоогүй зэрэг гэрээний үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.
4. Бусад эх үүсвэрээс санхүүжигдэх ТАХ-г Авто замын сангийн хөрөнгөөр санхүүжүүлж зориулалт бусаар зарцуулсан байна.
5. Холбогдох төрийн байгууллагууд захиалагчийн хяналтыг хангалтгүй хэрэгжүүлснээс сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим ажил чанаргүй хийгдсэн байна.
6. Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ихэнх ажлууд иргэдэд үр дүнгээ өгсөн байна.

ЗӨВЛӨМЖ

Аймгийн Засаг дарга О.Пүрэвдорж танаа:


1. Сумдын Засаг даргын албан бичгээр ирүүлсэн тооцоо, судалгаа, саналд үндэслэн хэрэгцээ шаардлагын дагуу ач холбогдлоор нь эрэмбэлж авто замын сангийн хөрөнгөөр хийгдэх ТАХ-ний санхүүжилтийг хуваарилан, баталж байх.

Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга Ц.Идэрсайхан-д:

1. Авто замын сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа ТАХ-ний техник хяналтын зардлыг эрх бүхий мэргэжлийн байгууллага захиалагчтай гэрээ байгуулсны үндсэн дээр шилжүүлж хяналт тавьж ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллах
2. Гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй гүйцэтгэгч нарт хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага тооцож, гэрээнд заасны дагуу хэтэрсэн хоног тутамд алданги тооцон санхүүжилтээс суутгаж байх. /2021-2023 онд хэрэгжсэн ТАХ-ний зардлаас тооцсон алдангийн дүн 4.3 сая төгрөг/

Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга Б.Мөнхбат-д:

1. Авто замын сангийн хөрөнгөөр хийгдэх ТАХ-г төлөвлөхдөө аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд туссан ажлыг ач холбогдлоор нь эрэмбэлж төлөвлөж байх.



2. Ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт, хууль, журам, стандартын дагуу захиалагчийн хяналтыг тавьж, үүрэг даалгаврын биелэлтийг тооцож ажиллах.
3. Авто замын хяналтын улсын байцаагчийг ажил тус бүрд явцын хяналтыг үе шат бүрд тавьж ажиллах
4. Хаус хороолол доторх хайрган авто зам, Авто тээврийн газрын гадна талбай, Тэмүүлэл эрдэм сургуулийн авто зогсоолын ажлуудыг хүлээн авах үед барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын өгсөн үүрэг даалгавруудын биелэлтийг бүрэн хангуулж, дутуу хийгдсэн ажлуудыг гүйцээн хийлгэх.

Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Идэрсайхан-д:

1. Тендерийн баримт материалын эмх цэгц, бүрэн бүтэн байдлыг хариуцах, цахим баримт бичиг түүний талаарх өгөгдлийг хадгалах нөөц хувийг бүрдүүлж, устаж үрэгдэхээс сэргийлэх зорилгоор хадгалалт хамгаалалт, зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2024 оны 12 дугаарын 10-ны дотор ирүүлнэ үү. Зөвлөмжийн биелэлтийг тооцож, нотлох баримтыг хангуулан 2025 оны 4 дүгээр сарын 01-ны дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 15 өдөр

Дугаар А/29

Арвайхээр сум

Гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дүгээр зүйлийн 6.3 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх, үүрэг”-ийн 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутагт хэрэгжиж буй авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан /ӨВА-2024/29-1-ШТА-ГА/-г нэгдүгээр хавсралтаар, аудитын шалгалтаар тогтоосон акт, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2024 оны 12 дугаар сарын 10-ний дотор, зөвлөмж, албан шаардлага, актын биелэлтийг бүрэн хангуулж, биелэлтийг 2025 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хариу мэдэгдэхийг Засаг дарга (О.Пүрэвдорж), аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга (Ц.Идэрсайхан), ХБТХОХ-ийн дарга (Б.Мөнхбат) нарт тус тус зөвлөсүгэй.

3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2025 оны 2 дугаар улиралд гаргаж танилцуулахыг аудитын менежер (Д.Гансүх), гүйцэтгэл-нийцлийн багийн ахлах аудитор (П.Хорлоосүрэн) нарт үүрэг болгосугай.

4. Тайланг Үндэсний аудитын газар, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.

5. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (П.Хорлоосүрэн)-д үүрэг болгосугай.



О.БАТЖАРГАЛ

015010078

D:\Audiitiin gazar\Baiguullagiin dotood barimt\Tushaal

Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны А29/тоот тушаалын хоёрдугаар хавсралт

Аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалт

№	Зөрчлийн товч утга	Акт, албан шаардлагын дугаар	Мөнгөн дүн /сая.төг/
1	Арвайхээр сумын 4 дүгээр Цэцэрлэгийн авто зогсоол хийх ажлыг 2022 онд хувийн хэвшлийн 45.7 сая төгрөгөөр хийсэн санхүүжилтийг нөхөн олгох зориулалтаар олгосон байна.	31/A1560347/ӨВА-2024/29-1-ШТА-ГА	45.7
2	Хайрхандулаан сумын Засаг даргын 2023 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 1/32 тоот албан бичгээр 2020 оны үерт нэрвэгдсэн гүүрний даланг засварлах ажилд 8.5 сая төгрөгийг шийдвэрлүүлэхээр хүсэлт ирүүлсний дагуу Авто замын сангаас тус хөрөнгийг шийдвэрлэсэн боловч одоог хүртэл гүүрний засварын ажил хийгдээгүй байна.	378/A1560347/ӨВА/2024/29-1-ШТА-ГА	8.5
3	Хархорин сумын авто замын нөхөөс – 20.0 сая төгрөг, авто замын хэвтээ тэмдэг, тэмдэглэгээ – 15.0 сая төгрөгийн 2023 оны ажлыг хуулийн дагуу худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй шууд гэрээ байгуулсан нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8.1.1 дэх заалтуудыг зөрчсөн байна. ¹	379/A1560347/ӨВА-2024/29-1-ШТА-ГА	35.0

D:\Auditiin gazar\Baiguullagiin dotood barimt\Tushaal

Монгол улс, Өвөрхангай аймаг
Арвайхээр сум, Нутгийн удирдлагын ордон
Утас: +976 70323253, 70323833, 70323108
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn, цахим хуудас: www.audit.mn